

## Радио сэтгүүл зүйн төрөл зүйлийн асуудалд

Л. Гүнсэн\*

\* Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн, Ахмад сэтгүүлч, РТДС

**М**онголын Радио тулгын чулуу-гаа тулсан цагаас хойш 69 жилийн түүх элээсэн. Эхний үед сонины материал, нам засгийн тогтоол, шийдвэр голлон нэвтрүүлж байсан учраас мэдээ, өгүүлэл төдийхөн зонхилж, дуу хөгжим, уран сайхны нэвтрүүлэг хавсарч байсан юм. Дөчөөд оноос мэдээ, товч тэмдэглэл, сурвалжлага, тойм нэвтрэх болсон. Харин зарим судлаач манай анхны радио шууд сурвалжлагыг 1941 онд Хувьсгалын музейгээс хийсэн гэж үздэг. Шууд сурвалжлага нь тухайн үйл явдал дууссан цагт л төгсдөг. Харин алив үйл явцаас юмуу аль нэг газрын үйл ажиллагаанд сурвалжлагч оролцоод сонсогчдын нүдэнд үзэгдтэл дүрслэн өгүүлсэн радио сурвалжлага хожуу гарч ирсэн бололтой.

Монголын Радиод радио бичлэгийн төрөл зүйлийн хувьд хөлд орж, тэнцэж ирсэн үе бол тавиад оны эцэс жараад оны эх гэж хэлж болно. Миний бие оюутан ахуй цагаас радио нэвтрүүлгийг идэвхтэй сонсч, бас ч идэвхтний журмаар зарим редакцийн нэвтрүүлэгт гар бие оролцож ирсний хувьд

1957, 1958 оноос нэвтрүүлгийн байдал өнгө аясыг тоймлоно. Энэ үе бол нэгдэлжих хөдөлгөөн, сүүлдээ соёлын довтолгоон гээд орон даяар өрнөсөн их хөлийн ажилд хүн ардыг нийтээр нь босгох аянд хэвлэл мэдээллийн ажилтнууд, тэргүүн эгнээнд нь радиогийн уран бүтээлчид нэгэн зэрэг боссон дуулиант үе байлаа. Ингээд ч цаг үе амьдрал бол уран бүтээлчдэд чиг хандлагыг нь тодруулж өгдөг болохоор радио нэвтрүүлгийн хэлбэр хийцэд нөлөөлж, радио сэтгүүл зүйн төрөл зүйл баяжихад эрчимтэй түлхэц үзүүлжээ. Радио сонин сэтгүүл, радио дуудлага, үзлэг шалгалт гээд нэвтрүүлгийн үр өгөөжтэй сонин содон хэлбэр энэ үед л мэндэлж, энэ бүхнийг дагаад бичиж, сурталчилж байгаа сэдвийн зааг ялгаа, төрөл зүйл өргөжин тэлсэн билээ. 1959 онд эфирт анх мэндэлсэн "Соёлч" радио сонин гэхэд л сурвалжлагч Сүхийн ярианаас гадна хот хөдөөгийн соёлжилтын ололт дутагдлыг хурц тусгасан хэд хэдэн сурвалжлага нэгэн дугаарт орох нь ёс мэт байлаа. Радио сурвалжлагыг репортёр R-2, R-3 гэсэн хүнд аппарат үүрч, эсвэл

тоноваген машинаар явж газар дээрээс нь хийдэг, сурвалжлагаа зарим үед тэнд нь эргүүлж сонсгодоогоос архичин согтуу хүмүүст зодулахад хүрч байсан тохиолдлыг радиогийн суртлын редакцийг тэр үед толгойлж байсан, эдүгээ "Хүмүүн бичиг" сонины ерөнхий эрхлэгч Соёлын гавьяат зүтгэлтэн, сэтгүүлч Т.Галдан, тэр үеийн бидний хамтран зүтгэгч, ахмад сэтгүүлч, Соёлын гавьяат зүтгэлтэн Д.Амбасэлмаа, одоо Радиогийн "Хурд" агентлагт ахлах редактор байгаа, ахмад сэтгүүлч Д.Хас-базар нар бэлхнээ гэр-чилнэ.

Жараад оныг радио найруулал хөл дээрээ боссон, ер нь цэцэглэж эхэлсэн үе гэж хэлж болно. Нэвтрүүлгийн шинэ содон санаа хэлэхдээ авхаалжтай, одоо бодоход тэр үедээ сэтгүүл зүйн "генератор" болж байсан Жамбалын Зундуй гэдэг хүн МРТХЭГ-ыг толгойлж байхад 1961 онд тэр хүний санаачлагаар Зөвлөлтийн радиогоос туршлагатай найруулагч, сэтгүүлч хоёр хүнийг соёлын төлөвлөгөөгөөр урьж ирүүлж, нийт уран бүтээлчдэд радио сурвалжлага, радио найруулалын талаар хоёр хоногийн хичээл семинар явуулж, дараа нь тэднээс сонссон мэдсэнээ амьдралд хэрэгжүүлэх гэж манай уран бүтээлчдээс тэдэнтэй хамт томиллолтоор хөдөө явж хүртэл байсан. Сэтгүүлч Л.Шаравжамцын "Сайн сайхан бүхнийг ийм хүмүүс авчирна", Г.Гомбын "Тугийн цоморлиг" зурагласан радио

найруулалууд ингэж бүтсэн түүхтэй. Нэгийг нь нийслэлийн 6-р сургуулийн хөдөлмөр зуслан, нөгөө нь Сөгнөгөрийн пионерийн зусланд очиж хийсэн эдгээр шинэ содон нэвтрүүлгийг нийт бүтээлч ажилтнууд асар их сонирхож, анхаарал тавин сонсч ярилцаж, их зүйл шинээр мэдэж авч байсан билээ.

Радио бичлэгийн төрөл зүйлийн хяналт чанга байсан. Уран бүтээлч хүн аль нэг бүтээл туурвиж, хяналтад өгөхдөө ямар төрөл зүйлд хамаарахыг заавал бичиж өгдөг. Шат шатны хяналтынхан түүнийг зөв-шөөрвөл гарын үсгээ зурдаг, эс зөвшөөрвөл буцаадаг. Бүтээлч ажилтнуудын шуурхай зөвлөлгөөний нэг гол сэдэв нь аль нэг тодорхой сэдвийн төрөл зүйлийг тогтоох, маргаантай бол хэдэн шуурхайгаар ч

«  
*Ер нь хяналтын олон шат  
дамжлаг байсан нь одоогийн  
хэлж ярьж байгаа шиг  
зөвхөн өнөөх л улс төрийн  
хяхалт, шахалт биш,  
радиогийн уран бүтэлийн  
чанарыг сайжруулахад  
чиглэж байсныг үгүйсгэх  
аргагүй.*

»

дамнаж хэлэлцэх тохиолдол нэг биш удаа байдагсан. Ер нь хяналтын олон шат дамжлаг байсан нь одоогийн хэлж ярьж байгаа шиг зөвхөн өнөөх л улс төрийн хяхалт, шахалт биш, радиогийн уран бүтэлийн чанарыг сайжруулахад чиглэж байсныг үгүйсгэх аргагүй. Хяналтын энэ дамжлагуудад аль туршлагатай, хянуур няхуур хүмүүс сууж зөвхөн эх бичвэр уншаад зогсохгүй, түүнд орох яриа, дуу чимээг заавал сонсч, тэр бүхнийг зөвхөн агуулгын талаас төдийгүй, бичлэгийн хувьд эфирт тэнцэх эсэхийг шүүдэг, онц шаардлагагүй ганц үг илүү юмуу буруу

хазгай хэлснийг засуулдаг байсан! Радио найруулалд гэхэд урт өгүүлбэр, сунжирсан яриа хэзээ ч оруулж байгаагүй.

**Н**айруулал, сурвалжлага зэрэг бичлэгийн тодорхой төрөл зүйлээр байгууллага дотооддоо төдийгүй, гаднаас тодорхой сэдвээр уран бүтээлийн уралдаан үе үе зарлаж байр эзлүүлдэг байсан нь радиогийн уран бүтээлийн санг арвижуулах, уран бүтээлчдийн ур чадварыг дээшлүүлэхэд нөлөөлсөн гэж боддог. Энэ бүхний дүнд Монголын Радиогийн сэтгүүлч, нийт уран бүтээлчдийн уран чадвар түргэн өсч, бичлэгийн төрөл зүйл улам бүр хөлөө олж, цэгцэрсэн гэж хэлж болно. Радио найруулалын зүтгүүрт эхэлж сууж мөрөө үлдээсэн, одоо ч бүтээл туурвил нь алтан сан хөмрөгт нандигнан хадгалагдаж байгаа хүмүүсийн тоонд өвгөн зохиолч, сэтгүүлч Ө.Баасанжав, М.Чимэд, зохиолч, сэтгүүлч Ш.Шажинбат, Б.Шаравнямбуу, ахмад сэтгүүлч Л.Шаравжамц, тэдний араас зохиолч, сэтгүүлч Б.Цэдэндамба, З.Дорж, авьяаслаг сэтгүүлч Д.Пэлдэн, П.Одхүү, яруу найрагч Ц.Чимэддорж, Дан.Нямаа зэрэг авьяастан хүч түрэн гарч ирснийг дурдахад таатай байна. Ийм хүмүүсийн бүтээлч эрэл хайгуул, зоримог санаачлага бусаддаа халдварладаг юм. Радио найруулал хийхгүй бол сэтгүүлч биш юм шиг санагддаг нэгэн үе байсан. Миний бичсэн найрууллуудын зарим нь одоо ч радиогийн сан хөмрөгт байгаа. Мөн 1974 онд БНМАУ тунхаглагдсаны 50 жилийн ойгоор радио тууж бичихээр зориглосон удаатай. Санаа нийлсэн сайн нөхөдтэйгээ хүч хавсарсны ачаар энэ маань ч

мөрөөдөл биш биелэл болсон минь одоо мөн сан хөмрөгт үлдсэн. Хувьсгалын өмнөх 10 жилээс эхлээд улсын маань туулж өнгөрүүлсэн хагас зууны 10 жил бүрийн онцлогыг харуулж чадах зургаан баатрыг сонгож, тэгэхдээ тэр хүмүүсийн амьдрал хувь заяа хоорондоо тодорхой сэжмээр холбогдсон байхаар бодож зургаан зохиогчийн бүтээл нэгдээд "Энэ жарны төрх" нэртэй радио тууж бүтэж 1974 оны 9-р сард эфирт орсон нь магадгүй радиогийн сан хөмрөгт орсон анхны баримтат радио тууж болсныг ч үгүйсгэхгүй.

Нийтлэлийн тухайд гэвэл анх Зөвлөлтийн хэвлэлд "Колонка редактора" гэж тодорхой сэдвээр уншигчидтай санал бодлоо солилцох нийтлэлийн рубрик гарч ирсэнээс санаа авч бид "Эрэн цаг үйл явдал" нэвтрүүлэгт "Редакторын минут" гэсэн өлгөц сэдэж гарч ирсэн санагдана. Тэр маань баяжиж дэвжээд уянгын аястай, уран сэтгэлгээтэй болж ирсэн. Хожмоо эссе ч гарч ирсэн.

Ингэж радио уран бүтээлчид гартаа барих шинэ шинэ зэвсэгтэй болж тэр чинээгээр тэдний уран бүтээл жилээс жилд сонсогч олны таашаал хүлээж улмаар радиогийн нэр хүнд өсч 1984 онд Монголын Радио гэдэг их айл Сүхбаатарын одонгоор энгэрээ мялаасан түүхтэй. Түүнээс хойш радиогийн нэр хүнд буурсан гэж би хэлэх гээгүй. Харин яваандаа уран бүтээлчдийн маань гартаа барих багаж зэвсэгийн тоо хумигдаж, ир мөхсныг зоригтой хэлж чадна. Одоо Монголын Радиогийн олонх программ баахан хүний яриа ярилцлага хэлэх төдий

болж байна. Улаанбаатар гээд бусад радио ч энэ зуршлаас тойрч гарсангүй.

**Р**адио сэтгүүлчдийн хамгийн урдаа барьдаг гол зэвсэг гэж хэлж болох радио сурвалжлага гэхэд өнөөдөр үнэхээр эмгэнэлт байдалд ороод байна. Монголын радиогоор ч, Улаанбаатараар ч сурвалжлага гэсэн үг дуулдаж л байдаг. Сонсоод үзэхээр сайн л бол хэн нэгнийг шалгаасан асуулт хариулт, бүр заримдаа зүгээр нэг яриа аваад хойно урьд нь хэдэнд үг зүүж радио сурвалжлага гэж нэрлэсэн байх нь хэвийн үзэгдэл болсныг нуух юм алга. Энэ бол үнэндээ Үндэсний Радио маань радио сэтгүүл зүйн асуудалд төдий л анхаарахаа больсны тэмдэг гэхээс өөр аргагүй юм.

Радио найрууллын байдал ч үүнээс дээрдэх юм алга. Монголын Радиод найруулал сайн хийдэг ахмад болон шинэ залуу сэтгүүлчид бий л дээ. Гэхдээ тэдний үр нөлөө төдий л ажиглагдахгүй байгаа. Энэ нь бичлэгийн төрөл зүйлд шаардлага тавихаа болсонтой холбоотой болов уу. Ардын Хувьсгалын 80 жилийн ой угтаж Монголын Радиогоор аймгуудын Радио өдөрлөгүүд зохиогдсон юм. Өвөрхангай аймгийн өдөрлөгөөс ажиж байхад УИХ-ын гишүүн Ши.Батбаяр, мал зүйч эмэгтэй Дүгэрсүрэн

нарын тухай хоёр хөрөг найруулал цуварч орсныг санаж байна. Аль аль нь найруулал бүү хэл тэмдэглэл ч гэхэд бэрх. Жишээ нь: Батбаярыг 10 минут яриулаад, УИХ-ын гишүүн Ц.Өөлдөөр бас нөхрийн тухай нэлээн юм хэлүүлээд хооронд нь хэдэн үгээр хэлхсэн байдалтай. Үүнийг тэгээд нас бие жагссан, нэлээн туршлагатай сэтгүүлчийн гараас гарсан гэхэд би үнэхээр итгэмээргүй байсан. Малын эмчийн тухайд нь Өвөрхангай дахь

сурвалжлагч Ичин-хорлоо гэдэг хүн хийсэн юм билээ.

Бас л үүвэр түүвэр ярианы холбоосоо хөрөг гэж нэрлэчихсэн. За энэ ч яахав, хөдөөнөөс аж ахуйн чиглэлийн редактораар орсон гээд цагаатгаж болно гэхэд орой нь “Зуун билэг” студийн цагаар бас найруулал гээд зарлахад нь ёстой чихээ дэлдийлгэсэн маань юу

«

*Радио сэтгүүлчдийн хамгийн урдаа барьдаг гол зэвсэг гэж хэлж болох радио сурвалжлага гэхэд өнөөдөр үнэхээр эмгэнэлт байдалд ороод байна. Монголын Радиогоор ч, Улаанбаатараар ч сурвалжлага гэсэн үг дуулдаж л байдаг. Сонсоод үзэхээр сайн л бол хэн нэгнийг шалгаасан асуулт хариулт, бүр заримдаа зүгээр нэг яриа аваад хойно урьд нь хэдэнд үг зүүж радио сурвалжлага гэж нэрлэсэн байх нь хэвийн үзэгдэл болсныг нуух юм алга.*

»

болсон гээ. Циркийн ахмад жүжигчин Самбуугийн Мааяагийн тухай редактор П.Соёлдэлгэрийн хийсэн нэвтрүүлгийг би хэлж байна л даа. Таталбар хөрөг гэж тодорхойлсон энэ нэвтрүүлэгт Мааяагийн яриаг 3 тасалж бөөндөөд эхэн сүүл хоёрт нь тэр хүний зохиолын 2 дуу оруулаад болох нь тэр. Холбоос нь болхи, уран нарийн шигтгээ дүрслэл ч үгүй, ерийн

тоочсон өгүүлэмжтэй. Ур чадварын уурхай болсон уран зохиолын редакцийн цагаар ийм юм сонсоно гэж даанч бодсонгүй.

**М**иний тухайлж байгаагаар бол нэгдүгээрт, 90-ээд оноос хэвлэл мэдээллийн хэрэгсэл, түүний дотор Радио Телевизийн хяналт суларсан. (Би улс төрийн цензур яриагүй, уран бүтээлийн хяналт хараанаас гарсаныг хэлж байна) Хоёрдугаарт, энэ бол дэлхий нийтийн урсгал хандлага ч байхыг үгүйсгэхгүй. Ер нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл нийгмийн ухамсарт хамаардгаас хойш энэ бол тухайн эрэн үе, бодит амьдралыг дагаж хэлбэлздэг байж таарна. Иймээс хэвлэл мэдээллийн хэрэгсэл, үүний дотор радио сэтгүүл зүйн төрөл зүйл доголдож байгаа өнөөгийн хандлага өнийн биш, түр зуурийн үзэгдэл гэдэгт би эргэлзэхгүй. Төрөл зүйл сэргэнэ, удахгүй байраа эзэлнэ гэдэгт би итгэлтэй байна. Яагаад гэвэл сэтгүүл зүй бол бодит зам, чиг хандлагатай шинжлэх ухаан мөн.

#### **Ашигласан бүтээлийн жагсаалт**

1. Chantler P. 1997. Local Radio Journalism. New York.
2. Michael C. 1997. Radio Station. Boston.
3. Ружникова В.Н. 1984. Основы радиожурналистики. М.
4. Vincent M. 1995. The Remaking of Radio. New York.
5. William L. 1986. Radio Handbook. Washington.

#### **Некоторые вопросы жанров радиожурналистики**

В статье рассматриваются некоторые практические и методологические вопросы жанров радиожурналистики. Автор на основе практических материалов показал основные изменения в жанрах радиопередач и мастерстве репортёров и главные факторы, действующие на формы и содержания радиожурналистики. Также в статье анализируются роль и особенности единства формы и содержания радиопередач, место радио в системе средств массовой информации Монголии.